

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 06 дугаар сарын 07-ны өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-6</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>7-24</i>
<hr/>	
<i>1. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 03 дугаар дүгнэлт</i>	<i>7-8</i>
<i>2. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 02 дугаар дүгнэлт</i>	<i>8-23</i>
<i>3. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл</i>	<i>23-24</i>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 06 дугаар сарын 07-ны өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Б.Энхбаяр ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 14 минутад Төрийн ордны “Жанжсин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ш.Адьяа;

Чөлөөтэй: Н.Алтанхуяг;

Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Мөнхцэцэг, Ц.Сэргэлэн.

Хэлэлцэх асуудлын дараалалтай холбогдуулан Байнгын хорооны дарга Б.Энхбаяр хэлэлцэх асуудлын дарааллын хоёрт байгаа Үндсэн хуулийн цэцийн 03 дугаар дүгнэлтийг хэлэлцэх асуудлын нэгдүгээрт хэлэлцье гэсэн горимын санал гаргав.

Б.Энхбаяр: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5

Бүгд: 11

54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул Үндсэн хуулийн цэцийн 03 дугаар дүгнэлтийг хэлэлцэх асуудлын нэгдүгээрт хэлэлцэхээр тогтов.

Байнгын хорооны дарга Б.Энхбаяр Үндсэн хуулийн цэцийн 03 дугаар дүгнэлтийг хаалттай хэлэлцэх горимын санал гаргав.

Б.Энхбаяр: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 4

Бүгд: 12

66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул Байнгын хорооны хуралдаан 14 цаг 23 минутад хаалттай горимд шилжив.

Байнгын хорооны хуралдаан 15 цаг 51 минутад нээлттэй горимд шилжин, санал хураалтыг илээр явуулав.

Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 03 дугаар дүгнэлт

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ч.Батбямба, мөн газрын Байнгын хорооны асуудал

хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан референт П.Хулан нар байлцав.

Б.Энхбаяр: 1.Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт ““Гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл” гэж мэдээ, өгөгдөл, баримт сэлтийг нууцаар олох, цуглуулах, дамжуулах, хүлээн авах, илрүүлэхэд зориулагдсан техник, тоног төхөөрөмж, түүний бүрдэл хэсэг, программ хангамжийг хэлнэ.” гэж заасны “... илрүүлэх ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтад “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. ... Иргэний хувийн ба гэр, бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална;” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 14
Бүгд: 14
0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт ““Гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл” гэж мэдээ, өгөгдөл, баримт сэлтийг нууцаар олох, цуглуулах, дамжуулах, хүлээн авах, илрүүлэхэд зориулагдсан техник, тоног төхөөрөмж, түүний бүрдэл хэсэг, программ хангамжийг хэлнэ.” гэж заасны “... илрүүлэх ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 14
Бүгд: 14
0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 55 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 02 дугаар дүгнэлт

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын дээд шүүхийн шүүгч Ц.Цогт оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ч.Батбямба, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан референт П.Хулан нар байлцав.

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 02 дугаар дүгнэлтийг танилцуулав.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 02 дугаар дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, Д.Цогтбаатар, Д.Ганбат, Б.Дэлгэрсайхан нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Энхбаяр, Улсын дээд шүүхийн шүүгч Ц.Цогт нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Ш.Раднаасэд, Д.Ганбат нар үг хэлэв.

Б.Энхбаяр: 1.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.5.а дэд заалтад “анхан болон давж заалдах шатны шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах;” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад Монгол Улсын иргэн “... шударга шүүхээр шүүлгэх, ... эрхтэй. ...” гэж заасанд нийцээгүй байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.5.б дэд заалтад “хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн;” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад Монгол Улсын иргэн “... шударга шүүхээр шүүлгэх, ... эрхтэй. ...” гэж заасанд нийцээгүй байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.1 дэх заалтад “анхан болон давж заалдах шатны шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн;” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад Монгол Улсын иргэн “... шударга шүүхээр шүүлгэх, ... эрхтэй. ...” гэж заасанд нийцээгүй байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.3 дахь заалтад “шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар

зүйлийн 14 дэх заалтад Монгол Улсын иргэн “... шударга шүүхээр шүүлгэх, ... эрхтэй. ...” гэж заасанд нийцээгүй байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1 дэх заалтад “анхан болон давж заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийг зөрүүтэй хэрэглэсэн;” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад Монгол Улсын иргэн “... шударга шүүхээр шүүлгэх, ... эрхтэй. ...” гэж заасанд нийцээгүй байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.3 дахь заалтад “шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад Монгол Улсын иргэн “... шударга шүүхээр шүүлгэх, ... эрхтэй. ...” гэж заасанд нийцээгүй байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “... зөрүүтэй хэрэглэсэн эсэх, ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад Монгол Улсын иргэн “... шударга шүүхээр шүүлгэх, ... эрхтэй. ...” гэж заасанд нийцээгүй байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 172 дугаар зүйлийн 172.2.1 дэх заалтад “анхан болон давж заалдах шатны шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн;” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад Монгол Улсын иргэн “... шударга шүүхээр шүүлгэх, ... эрхтэй. ...” гэж заасанд нийцээгүй

байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 172 дугаар зүйлийн 172.2.3 дахь заалтад “шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад Монгол Улсын иргэн “... шударга шүүхээр шүүлгэх, ... эрхтэй. ...” гэж заасанд нийцээгүй байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 04 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяагаас 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг нэгтгэн хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ч.Батбямба, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан референт П.Хулан нар байлцав.

Тогтоолын төслийн танилцуулгыг Байнгын хорооны дарга Б.Энхбаяр танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Энхбаяр: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3

Бүгд: 11
72.7 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Нээлттэй хуралдаан 1 цаг 25 минут үргэлжилж, 19 гишүүнээс 15 гишүүн ирж, 78.9 хувийн ирцтэйгээр 17 цаг 07 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.ЭНХБАЯР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 06 дугаар сарын 07-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
10 цаг 14 минут

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Энхбаяр: Байнгын хорооны гишүүдийн өнөөдрийн амгаланг айлтгая. Хууль зүйн байнгын хорооны 2023 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанд Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулъя. Б.Энх-Амгалан гишүүн ирсэн байна. Раднаасэд гишүүн ирсэн байна. Дэлгэрсайхан гишүүн ирсэн байна. Цогтбаатар гишүүн ирсэн байна. Сандаг-Очир гишүүн ирсэн байна. Нямбаатар гишүүн ирсэн байна. Учрал гишүүн ирсэн байна. Пүрэвдорж гишүүн ирсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 02 дугаар дүгнэлт /Монгол Улсын шүүхийн тухай хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/

Хоёр.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 03 дугаар дүгнэлт /Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/

Бусад асуудлын хүрээнд “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны төслийг тус тус хэлэлцэх саналтай байна.

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүн байна уу. Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор горимын санал миний хувьд гаргая.

Хэлэлцэх асуудлын дараалалд эхлээд Цэцийн 2023 оны 03 дугаар дүгнэлтийг эхэлж хэлэлцье гэсэн ийм саналтай байна. 03 дугаар дүгнэлтийг эхлээд хэлэлцье, их олон оролцогч дуудсан байгаа. Хууль, хяналтын байгууллагуудын. Тэгэхээр тэрийгээ эхлээд сонсьё гэсэн ийм горимын санал гаргаж байна.

Горимын саналаар санал хураая. Санал хураалт.

Горимын санал 54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 03 дугаар дүгнэлтийг хэлэлцэж эхэлье. Холбогдох оролцож байгаа албан тушаалтнуудыг оруулаарай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22.3-т хэлэлцэх асуудлын шинж байдал, гишүүдийн саналыг харгалзан асуудлыг хаалттай хуралдаанаар хэлэлцэж болно гэж заасан байгаа.

Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 03 дугаар дүгнэлт. Гүйцэтгэх ажлын тухай зарим заалт Үндсэн хууль зөрчсөн тухай асуудалтай холбоотой байгаа. Их Хурлын тухай хуулийн 22.2-т хаалттай хэлэлцэхээр хуульд заасан болон төрийн нууцтай холбоотой асуудлыг хаалттай хуралдаанаар хэлэлцэнэ. 22.3-т хэлэлцэх асуудлын шинж байдал, гишүүдийн саналыг харгалзан асуудлыг хаалттай хуралдаанаар хэлэлцэж болно гэж

заасны дагуу холбогдох байгууллагуудаас нууцын журмаар тайлбар, мэдээлэл ирүүлсэнтэй холбоотойгоор хаалттай хэлэлцье гэсэн горимын санал гаргаж байна.

Энэ горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. 66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ. Горимын санал дэмжигдсэнтэй холбоотойгоор хуралдааныг хаалттай горимд шилжүүлнэ үү.

Одоо хуралдааныг нээлттэй горимд шилжүүлсэн.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 82.2.2-т энэ хуулийн 82.2.1-д заасны дагуу Байнгын хороод цэцийн дүгнэлтийг хэлэлцэн, санал, дүгнэлт гаргахдаа холбогдох хууль, тогтоолын Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн гэсэн зүйл, хэсэг, заалт бүрээр, хэрэв Монгол Улсын Үндсэн хуулийн хэд хэдэн заалтыг зөрчсөн бол Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалт бүрээр тус тусад нь санал хураалт явуулна гэж заасан байна. Энэ заалтын дагуу санал хураалтыг явуулна.

Эхний санал хураалт.

Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт “Гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл” гэж мэдээ, өгөгдөл, баримт сэлтийг нууцаар олох, цуглуулах, дамжуулах, хүлээн авах, илрүүлэхэд зориулагдсан техник, тоног төхөөрөмж, түүний бүрдэл хэсэг, программ хангамжийг хэлнэ.” гэж заасны “... илрүүлэх ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтад “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. ... Иргэний хувийн ба гэр, бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална;” гэж заасныг зөрчсөн байна

гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт 100 хувийн саналаар хүлээж авсангүй ээ.

2 дахь санал хураалт. Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт “Гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл” гэж мэдээ, өгөгдөл, баримт сэлтийг нууцаар олох, цуглуулах, дамжуулах, хүлээн авах, илрүүлэхэд зориулагдсан техник, тоног төхөөрөмж, түүний бүрдэл хэсэг, программ хангамжийг хэлнэ.” гэж заасны “... илрүүлэх ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө харууцна.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт 100 хувийн саналаар саналыг хүлээж авсангүй. Санал хураалт явуулж дууслаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 03 дугаар дүгнэлтийг хэлэлцэж дууслаа.

Цэцийн дүгнэлтийг хэлэлцсэн Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Энх-Амгалан танилцуулна.

14.55 цаг.

Дараагийн асуудалдаа оръё. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 2 дугаар дүгнэлтийг хэлэлцэж эхэлбэ.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор Монгол Улсын Дээд шүүхийн албан ёсны байр суурийг авах нь зүйтэй гэж бичиг явуулсан. Улсын Дээд шүүх өнгөрсөн 5 дахь өдөр нийт

гишүүдийнхээ хуралдаанаар Үндсэн хуулийн цэцийн 02 дугаар дүгнэлттэй холбоотойгоор холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгохтой холбоотой санал, дүгнэлтийг Улсын дээд шүүхээс хийсэн судалгааны баримтын хамт гишүүдэд ирүүлсэн байгаа. Та бүхэнд бас тараасан.

Улсын дээд шүүхийг төлөөлж Улсын дээд шүүхийн шүүх Цогтыг Байнгын хорооны хуралдаанд бас оролцуулж, хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор нэмэлт тайлбар өгүүлэх боломжтой бичгийг Улсын Дээд шүүхээс ирүүлсэн байгаа. Тийм учраас Цогт шүүгчийг бас урьж оролцуулаарай.

Улсын Дээд шүүх рүү 2023 оны 6 сарын 6-нд УИХ13/4918 тоот албан бичгийг Байнгын хорооноос хүргүүлсэн. Мөн 6 сарын 6-ны өдөр Улсын дээд шүүхээс Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаас гарсан саналыг Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.3-д заасны дагуу Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар уг ажлын хэсгийг ахалж ажилласан Улсын дээд шүүхийн шүүгч Ц.Цогт томилогдсоныг үүгээр уламжилж байна гэсэн бичиг ирүүлсэн байгаа. Цогт шүүгчийг 5 номерын микрофонд урьж байна.

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр миний бие оролцсон байгаа. Тийм учраас та бүхэнд Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн талаар товч танилцуулъя.

Монгол Улсын шүүхийн тухай хууль 2021 оны 3 сарын 1-ээс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. Яг 2 жил гаруй хугацаа болж байна. Шүүхийн тухай хуулийн зарим заалт тодруулж хэлэх юм бол 25 дугаар зүйлийн 25.7.5а, 25.7.5б заалт, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.1, 123.2.3 дахь заалт, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн

1.1, 1.3 дахь заалт, мөн хуулийн 40.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 172 дугаар зүйлийн 172.2.1, 172.2.2, 172.2.3 дахь заалт, 173 дугаар зүйлийн 173.4 дэх хэсэг Монгол Улсын үндсэн хуулийн зарим заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хэлэлцээд 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдөр Үндсэн хуулийн цэцээс 02 тоот дүгнэлт гаргасан байгаа.

Дүгнэлт хэсэгт гол хөндсөн асуудал нь Шүүхийн тухай хуульд зааснаар Улсын дээд шүүхийн харьяалан шийдэх хэрэг маргааныг 3 үндэслэлээр Шүүхийн тухай хуулиар хязгаарласан. Өөрөөр хэлбэл Монгол Улсын Дээд шүүх бүх хэрэг маргааныг хянадаг энэ зарчмаас татгалзуулсан бусад улс оронд байдаг. Нэг талаасаа онолын шүүх, нөгөө талаасаа хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах энэ үндсэн чиглэл рүү нь хандуулж тодорхой 3 үндэслэлээр Улсын Дээд шүүх хэрэг маргааныг хяналтын журмаар авч үзэж шийдвэрлэдэг байя гэдэг үндэслэлийг тавьсан. Эндээс эхний 2 буюу 25.7.5а. Анхан болон давж заалдах шатын шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах, 25.7.5б. Хуулийг Улсын Дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн гэдэг заалтууд нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх заалтад Монгол Улсын иргэн шударга шүүхээр шүүлгэх эрхтэй гэж заасанд нийцээгүй байна гэдэг дүгнэлтийг гаргасан. Нөгөө талд нь Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.5а, 25.7.5б дэх заалт, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.1, 123.2.3 дахь заалт, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1, 1.3 дахь заалт, мөн хуулийн 40.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 172 дугаар зүйлийн 172.2.1, 172.2.2, 172.2.3 дахь заалт, мөн хуулийн 173 дугаар зүйлийн 173.4 дэх хэсэг нь иргэдийн мэдээлэлд дурдсан Монгол

Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй байна гэдэг Цэцийн дүгнэлт гарсан.

Цэц шийдвэрээ гаргахдаа үндэслэл хэсэгтээ 2 үндэслэл дурдсан. 2 үндэслэл дурдсан. Үүний гол агуулга нь Улсын Дээд шүүхээс доод шатын шүүхийн шийдвэрийг анхан болон давж заалдах шатын шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн, хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн тохиолдолд хянан шийдвэрлэхээр хуульчилсан нь хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилгыг бүрэн хангаагүй, хэргийн оролцогчдын хяналтын шатын шүүхэд хандах боломжийг хязгаарласан байна. Тодруулбал хууль хэрэглээний нэгдмэл байдлыг алдагдуулсан бусад тохиолдлуудыг Улсын дээд шүүх хянах боломжгүй болгон явцууруулж хуульчилсан нь Үндсэн хуулиар баталгаажуулсан иргэний шударга шүүхээр шүүлгэх эрхийг хөндсөн байна.

Иймд Монгол Улсын шүүхийн тухай хууль болон Эрүү, Иргэн, Захиргааны процессын хууль хоорондын уялдааг хангах хүрээнд шударга шүүхээр шүүлгэх иргэний эрхийг хязгаарласан эрх зүйн хийдлийг арилгах шаардлагатай байна гэсэн ийм дүгнэлт гаргасан байгаа юм.

Товч агуулгыг нь хэлэх юм бол түрүүн бидний хэлэлцсэн 03 дугаар дүгнэлт бол Үндсэн хуулийн ийм заалтыг шууд зөрчсөн байна гэж гарсан. Энэ дүгнэлт болохоор зөрчсөн гээгүй нийцээгүй байна, хуулийн хийдэл байна, хуулийн хийдэл байна. Сая хэлсэн тэр 2 дахь үндэслэлд байгаа заалт, зүйлүүдийг тодотгох агуулгатай ийм заалт гарчхаад байгаа юм. Арай өөр. Шууд зөрчсөн гэж хэлээгүй.

Тийм учраас энэ заалт бол өөрөө Шүүхийн тухай хуулийн би бол тулгын 3 чулуу гэж хэлж болохуйц том шинэчлэлийнх нь нэг нь байгаад байгаа

юм. Өөрөөр хэлбэл Улсын дээд шүүх бол бүх хэрэг маргааныг цаашидаа хянан шийдвэрлэдгээ больё. Хууль хэрэглээний нэгдмэл байдлаа хангадаг юман дээр илүү төвлөрч ажиллая. Зүгээр энэ чинь маш их тийм цаас хэрэг маргаан дарагдсан ийм зүгээр шүүх болчихлоо. Хэрэг дээрээ Дээд шүүх гэдгийг л шүүх гэж үздэг, бусдыг нь шүүх биш ч юм шиг шүүхийн шийдвэр гэж үздэггүй хандлага руу орчихсон бүүр сүүлдээ. Дээд шүүх хүртэл нь явж байж энийг шийдвэр гэж үздэг ийм байдал руу орууллаа. Энэ нь өөрөө шүүхийн дотоодод шүүх эрх мэдлийн бие даасан байдал шүүх дотооддоо нөлөөлдөг байдал их нэмэгдэж байна. Хэрэг маргааныг хянан шийдвэрлэх замаар Дээд шүүх доод шатны шүүхүүдээ хэрэг дээрээ удирдаж нөлөөндөө оруулж байна. Чиглэл өгдөг байдал нөлөөлж байна. Бусад онолын тайлбарууд гаргадаг, эрх зүйгээ хөгжүүлж авч явдаг энэ ажлаа хийх ямар ч боломжгүй. Хийдэггүй ийм байдал руу их орлоо гэдэг олон эш үндэслэлээр, нөгөө талаараа Шүүхийн хуулийг анх гарч байх үед ажлын хэсгийн ахлагчийн хувьд бусад улс орны Дээд шүүхүүд ер нь ингэж манайх шиг бүх хэрэг маргаанаа хянаж үздэг юм уу гэдэг дээр парламентын судалгааны хүрээлэнгээр судалгаа хийлгүүлж, гишүүдэд тарааж байсан. Ийм юм байхгүй байгаа. Бусад улсын Дээд шүүхүүд бол маш онцгой, тодорхой заачихсан. Яг хууль хэрэглээний эрх зүйг хөгжүүлэхэд чиглэгдсэн зарчмын шинжтэй ийм асуудлуудыг л шийддэг болохоос биш, бүх хэргийг ингээд бүгдийг нь ингээд хянаад явж байдаг ийм шүүх байхгүй юм байна лээ. Яг зарчмын дагуу бид шигтгэсэн. Үндсэн хуулийн цэцийн маргаантай холбоотойгоор Улсын дээд шүүх хууль хэрэгжүүлсэн 2 жилийн хугацаанд юу болов, яаж хэрэгжиж байна вэ. Мөн Үндсэн хууль зөрчиж байна гэж үзэж байгаа юу эсэх дээрээ Улсын дээд шүүх Цэцэд бас байр сууриа илэрхийлсэн. Дээд шүүх бол энэ их зөв болсон. Үндсэн хууль зөрчөөгүй. Ер нь их зөв чиглэл рүүгээ Монголын шүүх эрх мэдлийн тогтолцоо орж байна. Дээд

шүүх илүү энэ хууль хэрэглээний нэгдмэл байдал ингээд янз янзаар шийддэг болчихсон энэ хяналт үндсэндээ хэрэг дээрээ хяналтаа алдчихсан. Энийгээ харин цэгцлэх, одоо шийдвэрүүдээ дэргэдээ бас чинь судалгааны хүрээлэнтэй болчихсон. Илүү онолын, илүү судалгаатай шийдвэрүүд, тайлбарууд гаргадаг. Тэрүүгээр дамжуулж хууль хэрэглээнийхээ нэгдмэл байдлыг бүх шатын шүүх дээр хангадаг энэ жишиг рүүгээ одоо яг ороод явж байгаа. Энэ бол их зарчмын зөв өөрчлөлт болсон гэдэг ийм байр суурийг нийт шүүгчдийнхээ хуралдаанаар хэлэлцээд, Цэцэд ирүүлж ийм байр суурьтай оролцсон. Тэр ч утгаараа Цэц дээр бол маргаан нэлээн онолын ч тэр, судалгааны хувьд ч тэр, улс төрийн хувьд ч тэр өргөн өнцгүүд хэлэлцэгдсэн, мэтгэлцээнтэй хурал болсон. Энэ хурал. Энэ нь ч гэсэн Цэцийн шийдвэр дээр анзаарагдаж байгаа. Яаж анзаарагдаж байгаа гэхээр Цэцийн шийдвэрт ерөөсөө үндэслэл хэсэг нь ерөөсөө ийм тал юм байгаа юм. Өөрөөр хэлбэл яагаад энэ нийцээгүй юм бэ, хэрвээ өргөтгө гэвэл яаж өргөтгөх юм бэ гэдэгтэй холбоотой асуудал Үндсэн хуулийн цэцийн хуралдаанд яригдаагүй. Би энийг хариуцлагатай хэлье. Өргөдөл гаргасан иргэд ийм ийм байдлаар өргөтгөж өгөөч гэж ямар нэг асуудал Цэцэд хандаагүй. Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч миний бие нэгэнт ийм асуудал хөндөгдөөгүй учраас би тийм байр суурь ямар ч илэрхийлэгдээгүй. Мөн Үндсэн хуулийн цэцийн гишүүдээс асуулт, хариултын явцад мэтгэлцээний шатад ийм асуудал бас хөндөгдөөгүй. Тэгтэл Цэцийн шийдвэрийн үндэслэл хэсэг дээр яг яаж юу нь болохоо больчихоод байгаа юм гэдэг юм байхгүй. Яг яагаад гэдэг зүйл байхгүй. Тэгэхдээ ийм өгүүлбэр байгаа. Бусад тохиолдлуудыг Дээд шүүх хянах боломжгүй болгоод явцууруулчихсан байна гээд байгаа юм. Тэгээд бусад гэж ямар тохиолдлыг ойлгох вэ гэдэгтэй холбоотой ямар ч өргөдөл, мэтгэлцээн өрнөөгүй, өрнөөгүй.

Хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилгыг бүрэн хангаагүй. Өөрөөр хэлбэл ямар зүйлийг бас нэмэх ёстой юм бэ. Өргөтгөх ёстой юм бэ гэж бас ийм асуудал яригдаагүй. Иргэд яриагүй. Ер нь бид нарыг Дээд шүүхэд гомдол гаргадаг эрхээр л нээж өгнө үү, хуучин шигээ л байя гэсэн ийм агуулга байдлаар мэтгэлцээн өрнөсөн гэдгийг би бас Үндсэн хуулийн цэцэд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцсон хүний хувьд хэлж байна. Энэтэй холбоотойгоор нэгэнт Цэцийн дүгнэлт гарсан учраас хүлээж авах уу эсэх асуудал дээр би бол бас гишүүд асуухаас өмнө би бол хүлээгээд авчихъя гэсэн бодолтой байгаа. Хүлээж аваад зарим зүйлийг нь тодотгочихъё, өөрчилчихъё. Үндсэн хуулийн институц хооронд бас бие биедээ хүндэтгэлтэй хандах ёстой. Улсын Их Хурал ч тэр, Үндсэн хуулийн цэц ч тэр бид бас Үндсэн хуулийн цэцийн шийдвэрт институцэд хүндэтгэлтэй хандаад, хүлээж аваад, тэгэхдээ энэ заалтаа дахиад тодотгоод боловсронгуй болгочихъё. Тэгэхдээ ингэж боловсронгуй болгох асуудлыг бол Их Хурал хэрвээ хүлээж авъя гэж шийдэх юм бол үүний дараа Байнгын хороо дээрээ яаж өөрчлөх вэ гэдэг асуудал нь яригдана. Яаж өөрчлөх вэ гэдэгтэй холбоотойгоор бол Улсын дээд шүүхээс бичгээр санал авсан. Энийг бол та бүхэнд тараачихсан байгаа. Мааш тодорхой санал ирүүлчихсэн байгаа. Нийт гишүүдийнхээ хурлаар. Энэ ирүүлсэн томъёоллынхоо яагаад гаргаж байгаа вэ гэдэгтэй холбоотой мааш том судалгааны тайланг хавсарган ирүүлчихсэн байгаа Улсын Дээд шүүх. Энэ тайлан судалгаатайгаар бол холбоотойгоор бас нэмж тайлбарыг Улсын Дээд шүүхээс бас төлөөллөөс асуух гишүүд бас ийм боломжтой байгаа шүү гэдэг зүйлийг нэмж хэлье ээ. Баярлалаа.

Ингээд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Дэлгэрсайхан гишүүнээр тасаллаа. Одонтуяа гишүүн асуултаа асууя.

С.Одонтуяа: Би Хууль зүйн байнгын хорооны гишүүн биш учраас өмнөх хуулиуд нь бас яаж батлагдсан, нарийн ширийн зүйлийг нь бол мэдэхгүй байна. Ер нь би бол бас бүх л зүйлүүдээр байнга шүүмжлээд санал бодол хэлээд байдаггүй. Яагаад гэхээр мэргэжлийн хүмүүс бол өөрсдөө мэдээд хууль дүрмээ оруулж ирж байгаа. Би бол бас бас нэг онцгой тохиолдлуудад энд саналуудаа хэлж байгаа. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт бол юу гэж гарсан бэ гэхээр энэ зүйл заалтууд нь Үндсэн хуулийн зүйл заалтуудыг зөрчсөн байна гээд дунд суудлынхаа хуралдаанаар шийдвэр гаргачихсан байна. 1 дүгээрт.

2 дугаарт манай энэ хуулийг бас санаачилсан итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр орсон Энхбаяр гишүүн бол бас би энд юуг бол хүлээж авъя. Тэгээд бид бол бас хоорондоо хийдлүүдээ арилгах ёстой гэдгийг хэлж байгааг бол сонслоо. Тэгэхээр ер нь зүгээр би энэ асуудлыг яагаад ярьсан юм бэ гэхээр хэд хэдэн зүйл байгаа юм. Одоо бид нар хүний эрхийн асуудал дээр бас их онцгой тийм мэдрэмжтэй хандахгүй бол их олон жилийн дараа асуудлууд үүсдэг. Хүн өөрөө ингээд бүх шатын шүүхээр хэрэг нь хянагдаагүй ийм тохиолдолд дандаа гомдол тээж явдаг. Эргээд энэ бол бүх шатын шүүхээр хянагаад ингэчихсэн хүмүүс бол бас үнэхээр шүүх ингэж шийдлээ гээд асуудлыг орхидог. Гэтэл бол нөгөө Үндсэн хуульд заасан хүний эрхэд суурилсан зүйлүүдээс бол зөрчсөн зүйлүүд байна л даа. Жишээлэхэд Монгол Улсын Дээд шүүх бол шүүхийн дээд байгууллага мөн бөгөөд давж заалдах болон хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэх Улсын Дээд Шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх бусад этгээд заавал биелүүлнэ. Энэ тэр гэгчихсэн ийм хэд хэдэн чухал заалтууд. Үндсэн хуулийн 48 дугаар зүйлд анхан, давж заалдах, хяналтын журмаар хянан шийдвэрлэх 3 үе шатаас бүрддэг бөгөөд гээд ингээд нарийн нарийн заачихсан

байна. Тэгэхээр би юу хэлэх гээд байна гэхээр би нөгөө Цагаатгалын комиссын даргаар ажиллаж байгаа. Энэ Цагаатгалын хэлмэгдлийн хэргүүдтэй танилцахад бол дандаа ийм түргэвчилсэн, хялбаршуулсан ийм аргаар шийдсэнээс болоод бид нар чинь 30, 40-өөд мянган хүнийхээ амь насыг алдчихсан. Дээрээс нь энэ дээр зарим шүүх дээр бол алдаа гарна. Яагаад гэхээр энэ хүмүүс тухайн үед энэ хэргийг шийдвэрлэхдээ өөрсдийнхөө зөв гэж бодоод л шийдвэр гаргаж байсан. Гэтэл хэрэгт тэр ял авсан хүмүүсийн 80 хувь нь цаазлуулсан байгаа байхгүй юу. Энэ чинь бүүр аймшигтай тоо байхгүй юу. Тэгэхээр би сая бас Солонгосын хэлмэгдлийн юмыг судлаад үзлээ. 1948 оны Чэжүгийн хэрэг, 1980 оны кванжуны хэрэг гээд бүх шатаар шийдвэрлэгдсэн хэргүүд одоо буцаад сөхөгдөөд хүний эрхийн зөрчлүүд нь ингээд гарч ирээд эргээд бүр маш том асуудал үүсээд, том том хороод ажиллаад ингээд байж байгаа юм. Тийм болохоор би хүний эрхийн асуудал дээр нэг хялбаршуулах гэсэн, жоохон цаг хожих гэсэн ийм зүйл бол эргээд том үр дагавар дагуулах вий. 7 сарын 1-ний асуудал гарсан. 7 сарын 1-нд маш олон гэмгүй 300 залуу ял авахдаа тэд нараас ерөөсөө буцааж гомдол аваагүй. Яагаад гэхээр төр бол тэр дээр төрийн буруутай шийдвэр байсан учраас нүдээ аниад өнгөрсөн гэх мэтчилэн ийм хэргүүд гарахгүй гэх цаашаа баталгаа байхгүй ээ. Тэгэхээр хүн гомдол байгаад гомдлоо цаашаа хэлж байгаа тохиолдолд би бол энийг яг үнэхээр дунд суудлаар зөв шийдсэн байна гэж хэлэх гээд байгаа юм. Хүний гомдол бол ерөөсөө тасардаггүй. Тэгэхээр энэ дээр дунд суудал нэгэнтээ Үндсэн хуулийн цэцээр дунд суудлаараа хэлэлцээд.../минут дуусав/

Б.Энхбаяр: 5 номерын микрофон.

Ц.Цогт: Сайн байцаана уу. Монгол Улсын Дээд шүүх Шүүхийн тухай хуулийг хэлэлцэж эхлэх үед бол ажлын хэсэгт илгээсэн өөрийн төлөөллөөрөө дамжуулаад энэ хэсэг дээр бол саналаа

өгч байсан. Тухайн үед хууль зүйн байнгын хорооны гишүүд бүгд байсан учраас санаж байгаа байх. Тэгэхээр Дээд шүүхийн санал бол юу байсан бэ гэхээр шүүхийн үндсэн тогтолцоо буюу 3 шатлалтай тогтолцоонд хяналтын шатын шүүхийн чиг үүрэг өөрийн чиг үүрэг гэж байдаг. Тэр нь бол хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтоох ийм үндсэн чиг үүрэгтэй. Тэгэхээр энэ чиг үүргээ хэрэгжүүлэхдээ бол бүх хэргийг авч шийднэ гэвэл нөгөө шийдээж ирсэн л дээ. Тэгэхдээ хамгийн гол нь нөгөө шүүн таслах ажиллагааны чанар маань хяналтын шатад маш цөөн шүүгч ажилладаг учраас тэгээд богино хугацаанд шийдэх ёстой. Тэгэхээр тэр шүүн таслах ажиллагааны чанарын асуудал үүсдэг учраас шинээр хуульд нэвтрүүлсэн гомдлыг Шүүхийн тухай хуульд заасан шалгууруудаар нь ангилж үзээд ингээд шийдвэрлэдэг, сонгож авсан хэргүүдээр буюу тэр шалгуурт хангагдсан хэргүүдээр дамжуулж ижил төстэй хэргүүд дээр тухайн хуулийг нэг мөр тайлбарлаж хэрэглэх шинэ системийг нэвтрүүлж байгааг бол зөв гэж үзсэн. Зарчмын хувьд. Тэгэхдээ тухайн үед бол шүүхийн төлөөллөөс бол ямар санал гаргаж байсан юм гэхээр арай бас явцуу, арай хязгаарлагдмал байдлаар бол бас томъёологдож байна. Тийм учраас томъёоллыг бол бас арай дэлгэрүүлэх ийм боломж бол байвал хууль тогтоогч энийгээ анхаараач гэдэг ийм саналыг бол тухайн үед гаргаж байсан.

Тэгээд яах вэ зүгээр сая Одонтуяа гишүүний ярьдаг юмыг би зөв буруу ойлгоогүй бол тэр өмнөх Онцгой комиссын асуудал бол шүүхээр орсон зүйл ихэнх нь бол шүүхээр ороогүй шүү дээ. Тэгээд тэр бол шүүхээс гадуур, хууль бус ийм байгууллага байгуулж шүүн таслах ажиллагаа эхлүүлснээс тийм үр дагавар гарсан байдаг. Тэрийг бол давтахгүй байх ёстой. Одоо хяналтын шатын шүүхийн чиг үүрэг бол тэр процессын алдаа юу байна гэдгийг тэр шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 7.5в гэсэн заалт байгаа. Шүүхэд

хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гарсан энэ нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн бол гэдэг энэ үндэслэлээр гарсан гомдолд хэрвээ тийм үндэслэл байвал аваад зөрчлийг нь арилгуулахаар буцаагаад анхан шатны шүүх рүү нь давж заалдах шатны шүүх рүү нь буцааж байгаа.

Б.Энхбаяр: Одонтуяа гишүүн тодруулж асууя.

С.Одонтуяа: Хэлмэгдлийн үеэр шүүхээр ороогүй гэж хэлж болохгүй л дээ. Энэ чинь өөрсдөө яг энэ шиг ингээд л зүв зүгээр ажиллаж байсан шатны шүүхээ өөрчлөөд л онцгой байдлын шүүх гэж тусдаа гаргаад л, тэгээд л 3 хүнтэй. Энэ нь өөрөө ерөөсөө өдөрт хэдэн мянгаар нь хүмүүсийг шүүгээд л шүүх хурал хийсэн гэж үзээд л ингээд явчихсан байхгүй юу. Юмыг хялбаршуулсан. Хэдэн мянган хүнийг тэгж хэлмэгдүүлсэн. Дээрээс нь одоо энд та Үндсэн хуулийнхаа 44 дэх заалтыг тэгээд яах юм. Ингэж байна шүү дээ. Улсын 3 үе шатнаас бүрддэг бөгөөд дээрх 3 шатын хүрээнд эрх зүйн маргааныг шийдвэрлэнэ гээд. Тэгэхээр Үндсэн хуулийн цэц чинь бүүр цагаан дээр хараар биччихсэн байна л даа. Шударга шүүхээр шүүлгэх эрхтэй гэж заасанд нийцээгүй байна гээд ингээд заачихсан байгаа байхгүй юу. Яг энэ зүйл заалт чинь зөрчсөн байна гэдгийг. Тэгэхээр энэ Үндсэн хуулийн яг энэ үндсэн.../минут дуусав/

Б.Энхбаяр: Би бол итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хувьд хариулахад Үндсэн хуулийн цэцийн шийдвэрээс Одонтуяа гишүүний асууж байгаа асуултын хариулт олдохгүй байгаа. Өөрөөр хэлбэл шударга шүүхээр шүүлгэх эрхийг яагаад зөрчсөн юм бэ гэдэг нь байхгүй байгаа. Үндэслэл хэсэг дээр нь уг нь байх ёстой байхгүй юу. Түрүүний тэр 02 дугаар дүгнэлт дээр бол тэр үндэслэл хэсэг чинь 3 хуудас байгаа биз дээ. Яагаад ингэж үзсэн юм бол, Цэц яагаад ингэж үзэв гэдгээ тайлбарлачихсан байгаа байхгүй юу. Энэ

дээр болохоор тийм юм байхгүй байгаад байгаа юм. Яагаад гэдэг асуултад таны асууж байгаа энэ асуултад хариулт нь Цэцийнхээ шийдвэр дээр байхгүй байгаа. Би түрүүн хэлсэнчлэн энэтэй холбоотой мэтгэлцээн өрнөөгүй байхгүй юу. Тэгсэн мөртөө шийдвэр нь шударга шүүхээр шүүлгэх эрхийг зөрчсөн байна гээд гарчихсан. Тийм учраас асуултад бол Улсын Дээд шүүхийн шүүгч бол бас Цэцийн өмнөөс бол хариулахад мэдээж төвөгтэй байх.

Онолын хувьд 3 шатны шүүх байна. Улсын дээд шүүх гэсэнтэй холбоотой тэр хэсэг дээр бол харин тайлбар өгч болох байх.

5 номерын микрофон нэмж хариулъя.

Ц.Цогт: Одонтуяа гишүүний асуултад нэмж хариулъя. Тэр ер нь шударга шүүхээр шүүлгэх эрхийг томъёолдог томъёолол байдаг л даа. Тэр нь бол жишээлбэл нөгөө улс төрийн болон иргэний эрхийн факт. Тэгээд үүнийг НҮБ-ын тэр хүний эрхийн хорооноос тайлбарласан байдаг юм. Яг энэ агуулгад юу багтах вэ гээд. Тэгэхээр яг таны хэлж байгаа шиг шударга шүүхээр шүүлгэх эрх бол 2 агуулгаас бүрдэж байгаа юм.

1 дүгээрт шүүх гэж байгаа байгууллага нь өөрөө шударга байх. Энэ нь бол жишээлбэл мэргэжлийн байх, улс төрөөс хараат бус байх гэх мэтчилэн энэ шалгууруудаар .

2 дугаарт процесс нь шударга байх. Шүүн таслах ажиллагаа нь гэсэн үг. Тэр дотроо нэг чухал шалгуур нь бол таны хэлдэг нөгөө шүүхийн шийдвэрт давж заалдах эрхтэй байх. Энэ эрхийг зааж өгсөн байдаг. Тэр НҮБ-ын хүний эрхийн хорооны тайлбараар бол ер нь олон улсынхаа.../минут дуусав/

Б.Энхбаяр: Дараагийн гишүүдийн асуултад хариулахад бас нэмээд

хариулчхаарай. Цогтбаатар гишүүн асуултаа асууя.

Д.Цогтбаатар: Ингээд бүх хэрэг 3 шатаар яваад заавал Дээд шүүх дээр очиж дуусдаг байсныг халах асуудал тухайн үедээ яригдаад, тэр үед яригдаж байсан үндэслэл рационалиудыг харж байхад тэр бол үнэхээр зөв байсан. Энэ өрөө нээрээ урагшаа гишгэсэн ахиц байсан. Ер нь бусад орнуудын шүүхийг үзэхэд нээрээ Дээд шүүх рүүгээ бүгд явдаг тийм юм бол байхгүй ээ. Тэгэхээр энэ нь бол зөв байсан. Гэхдээ энэ дээр нэг хэд хэдэн юм бас бид нар нээрээ одоо тэгвэл амьдрал өөрөө баян учраас энийг баяжуулахаас өөр болохгүй нь ээ гэдэг амьдрал дээр өөрөө туршигдаад буцаад л ороод ирж байна л даа. Тийм учраас бид нар энийг авч хэлэлцэхээс өөр үггүй байгаа юм. Тэгээд би дээр Цогтоо шүүгчээс нэг юм зүгээр асуумаар байгаа юм. Юу гэхээр урьд өмнө нь нээрээ энийг ингээд хэлэлцээд өөрчлөх хүртэл тэр судалгаа хийгдсэн байх ёстой. Өөрөөр хэлбэл Дээд шүүх дээр очоод буцаж байгаа хэргүүдийн хэд нь өмнөх шүүхийнхээ хэдэн хувь нь эс үгүй бол хувиар нь гаргаж чадах юм бол хэдэн хувь нь өмнөх шүүхийнхээ шийдвэрийг өөрчилж, өөрөөр хэлбэл өмнөх шүүхийн шийдвэрээ давах шатын шүүхийнхээ шийдвэрийг баталгаажуулаад хэдэн хувь нь гарч байсан, хэдэн хувь нь өөрчилж байсан юм гээд. Энийг бас нэг ийм статистик мэдээлэл судалгаа байгаа юу. Шударга шүүх гэдэг дээр бол яг би тантай санал нэг байна. Угаасаа шударга шүүх гэхлээр заавал 3 юм уу, 4 юм уу тоо заагаагүй байдаг. Давах шатын шүүхтэй байх ёстой. Мэргэжлийн байх ёстой, хараат бус байх ёстой. Энэ нь хангагдаж байвал бол шударга шүүх гээд. Түүнээс олон улсын хүний эрхийн аливаа гэрээ конвенцууд дээр бол хэдэн шаттай байхыг бол тусгайлан заагаагүй байдаг. Тухайн улсын өөрийнхөө хуулиар шийднэ.

Одонтуяа гишүүнд харин нэг санал тавьчихмаар байх юм. Энийг

далимдуулаад. Яг цагаатгалын комисс даргалж байгаа хүний хувьд бол саяын таны ярьсан асуудал Цогтоо шүүгч бид нар ч гэсэн энийг анхаарч байх ёстой. Монголын нийгэмд зүрхэнд хурсан аймшиг, эмзэглэл байгаа. Энэ сэтгэл зүйн факторыг бид нар тооцож үзэхгүй байж болохгүй. Тэгээд энэ дээрээ юу хийсэн гэхээр бид нар энд хэлмэгдүүлсэн хүмүүсийг 1937 он эд нарынхыг бол бүр ингээд өнгөрчихсөн болохлоор үлдээчихсэн. Хэлмэгдсэн хүмүүсийнхээ хохирлыг нөхөөд яваад байгаа болохоос биш хэлмэгдүүлсэн хүмүүс дээр ямар ч хариуцлага тооцоогүй үлдээчихсэн байж байгаа. Энэ эрсдэл цаашаа үргэлжилсээр байгаа бөгөөд хэлмэгдүүлж байгаа хүмүүс дээр хариуцлага тооцдог энэ тогтолцоог бол та бараг ер нь санаачилж оруулж ирэх ёстой. Яагаад гэвэл энэ эрсдэл өнөөдөр ч байгаа. Монгол улс өнөөдөр ч улс төртэй байгаа. Улс төрийн зорилгоор хэнийг ч хэлмэгдүүлж болзошгүй байгаа. Дарга нар хууль шүүхийн байгууллагад нөлөөлөх эрсдэл хэвдээ байгаа. Энийг хаах ёстой байхгүй юу. Яаж хаах вэ гэхээр хариуцлага гарцаагүйд тооцоод тэр хүний үгээр хийгээгүй хэргийн төлөө хүнийг хэрэв шийтгэж байгаа бол тэр хүн зүгээр өнөөдөр ч гэсэн хуулиараа хариуцлага хүлээх тогтолцоо бий. Гэхдээ тэр хангалттай биш байхгүй юу. Захиалгаар тийм юм хийж байгаа бол жилийг нь нэмж өгөх ёстой. Авлигачдад 20 жил гээд ял терроризмтой адилхан хэмжээний ял тавьж өгч байгаатай адилхан хүнийг буруугүй байхад захиалгаар шийтгэсэн хүнийг 20 жил суулгадаг байх ёстой. Тэгэхлээр тийм юуг та харин санаачилж оруулж ирэх ёстой гэж би бодож байна.

Б.Энхбаяр: 5 номерын микрофон.

Ц.Цогт: Цогтбаатар гишүүний асуултад ер нь өнгөрсөн 5 жилийн статистикаар бол Монгол Улсын шүүх анхан шатын шүүхэд нийтдээ 421,493 хэрэг хүлээж авч шийдсэн байна. Анхан шатын журмаар. Үүнээс 8,5 хувь нь

давж заалдах шатны шүүх рүү гомддог юм байна. Өөрөөр хэлбэл үлдсэн хувь нь анхан шатын шүүхийн шийдвэр гарснаар шийдвэр эцсийн болдог гэсэн үг. 8,5 хувь нь. Ингээд үүнээс зүгээр яах вэ Эрүү, Иргэн, Захиргаагаараа жаахан ялгаатай юм байна. Тэгээд аль захиргаа нь илүү их гомддог юм байна. Ер нь бол захиргааны шүүхийн шийдвэрт илүү их гомддог юм байна. Сая 2021 оны шүүхийн хуулийн өөрчлөлт орж ирсэнтэй холбоотойгоор Улсын дээд шүүх хяналтын журмаар ирсэн асуудлыг 2 шатлалтай хэлэлцдэг болсон. 1 дүгээрт нийт гомдол хэрэг гарсан хэрэг хуульд заасан шаардлагыг хангаж байна уу, үгүй юү гэдгийг танхимын 8 шүүгч эсвэл 6, 7 шүүгч бүгд сууж байгаад бүгдээрээ хэлэлцдэг нэг шаттай болсон. Энэ нь бол бараг хуучин тогтолцоогоор бүх хэргийг хэлэлцэж байсантай адилхан хэмжээний тийм урьдчилсан бэлтгэл ажлын үндсэн дээр энэ хурал болдог болсон байгаа. Тэгээд эндээс саяын заасан 3 шалгуурт нийцсэн гэж үзсэн хэргүүдийг хяналтын шатын хуралдаанаар буюу дахиад тусгай дотоод өөрсдөө хийсэн журмын дагуу бэлдэж байгаад нөгөө нэг ижил төстэй хэрэг байна уу, хүрээлэн рүүгээ онолын судалгаа хийлгэж байгаад арай нэг түрүүний ярьдгаар, яагаад гэвэл цаашидаа энэ сонгож авсан хэрэг тэр төрлийн хэрэг маргаанууд дээр нөгөө казиностик прецидент болох ийм агуулгатайгаар шийдэж байгаа байхгүй юу. Тэгэхээр бол харьцангуй тогтолцоо нь бол үр дагавраа өгөх шинж бол байна гэж бид бас үзэж байгаа. Саяын тэр юуны хувьд бол хэдэн хувь нь буцаад яг шийдэгдэж байгаа вэ гэдэг дээр бол яг одоо миний гар дээр яг тэр хувийн тоо бол алга байна. Ер нь бол саяын хэлж байгаагаар бол та нийт анхан шатын шүүхийн 8,5 хувь нь давдаг. Давахын шүүхийн бол шийдсэн хэргийн 54 хувьд нь хяналтын шат руу гомдол гардаг юм байна. 54 хувьд нь. Тэгэхээр давхрын шүүх бол өнгөрсөн 5 жилийн хугацаанд гэхэд 10,702 хэрэг нийт давж заалдах шатын шүүхэд хэлэлцсэн байна. Тэгээд эндээс 54 хувь нь Дээд шүүх рүү

хяналтын гомдол гардаг ийм л тоо харагдаж байна. Тэгээд яах вэ Дээд шүүхийн тоо бол тодорхой байна л даа. Өнгөрсөн 2 жилийн тоог би хэлье л дээ. Иргэний хэргийн танхим 251 хэрэг шийдсэн. Энэ нь бол нийт гарсан гомдлын 10 орчим хувь нь байгаа. Захиргааны хэргийн танхим болохоороо 110 хэрэг буюу нийт гарсан гомдлын 12,6 хувь, эрүүгийн хэргийн танхим 284 буюу 19,3 хувь бол хүлээж авч хяналтын журмаар шийдэж байгаа. Өөрөөр хэлбэл нөгөө 2 дахь хуралдаанаараа. Эхний хуралдаанаараа бол гомдол гарсан бүх хэргийг гомдол нь анхан шатын, давахын шүүхийн шийдвэртэй хамт судлаад энд бол нөгөө саяын асуудлууд байгаа юм байна, байхгүй юм байна гэдэг ийм шийдвэрийг гаргаж байгаа.

Б.Энхбаяр: Ганбат гишүүн асуултаа асууя.

Д.Ганбат: Үндсэн хуулийн цэц нь хууль тогтоож байх шинжтэй. Тэгээд тэндээс ямар ч юм гарч ирээд яагаад ч байгаа юм. Шүүх бол хараат бус байх ёстой. Бие даасан шийдвэр гаргаж байх ёстой. Тэрнээс биш анхан шатны шүүх нь аль ч шатандаа хараат бус шийдвэр гаргаж байх ёстой шүү дээ. Зөвхөн хуулийг дээдэлж, тэгж ойлгоод байгаа. Тэгээд яагаад танай 3 шатын шүүх чинь 3 өөр шийдвэр гаргаад байдаг юм бэ. Хэрэв тэр хараат бус шүүхээр шийдүүлж чадаагүй юм бол тэр шийдсэн шүүгчид нь ямар арга хэмжээ аваад байна. Сүүлийн 7, 8 жил бол шүүх, шүүгчийн нэр хүнд бол асар их унасан. Улсын дээд шүүхийн 20 хэдэн шүүгч байдаг билүү. Тэрний талаас илүү хувь нь бол ямар нэгэн байдлаар ямар нэгэн асуудалд орооцолдсон гэж хэвлэл мэдээллээр яриад байгаа. Бүр нэр ус зааж байгаад. Тэгээд энийг юу гэж ойлгох вэ. Тэгээд тэр нь ч гэсэн үнэн юм шиг байгаа юм. Ер нь дохио зангаагаар л эрх барьж байгаа нөхдийн дохио зангаагаар л шүүгч нар ажиллаж байгаа. Ялангуяа Дээд шүүх бол. Одоо энэ хэдийг яаж шийдэхийг хар гээд л. Дүрэм

журмаа өөрчлөөд л тамга тэмдэггүй юмыг хүлээж ав гээд л. Тэгээд Шүүхийн ерөнхий зөвлөл байгаа. Одоо энэ их сайжруулаад шүүхийн хуулийг янзалж бариад хараат бусыг нь бүүр сайжруулаад ингэчихлээ гэсэн. Тэрэнд нь бол би эргэлзэж байгаа. Одоо энэ хууль нь хэрэгжиж бариад 2, 3 жил өнгөрчихлөө. Нэг их сайжирсан юм алга. Тэр шүүгчийг сонгон шалгаруулах, зөв хүнийг тавьж ажиллуулах, Шүүхийн ерөнхий зөвлөлийг харж байхад бол шүүхийн нэр хүндэд халдлаа, шүүгчийн нэр хүндэд халдлаа гээд нэг шийдвэр гаргадаг. Тэгснээ бид нар тэгж гаргаагүй шүү дээ гээд л гөлгөнөөд л, гөлөлзөөд л байж байх жишээтэй. Энэ тэр ямар учиртай юм бэ. Энийг хараат байна гэж ойлгох уу, хараат бус байна гэж ойлгох уу. Анхан шатны...та хариулах хэрэггүй ээ, би тэр шүүхийн хүнээс нь л асуугаад байна. Хоёулаа цэц булаацалдаад таарна шүү дээ хэрэггүй. Тэгээд хамаг амь амьдралаа гаднын хөрөнгө оруулалтууд тэр чинь бүгд байхгүй болчихсон шүү дээ. Ийм дээд шүүхтэй юм чинь ийм л байгаа. Үүний гол буруутан нь ул нь Үндсэн хуулиар бол засаглалын нэг болох шүүх бол ерөөсөө 500 л хүн байгаа л даа. Би анхан шатын шүүгч нарыг бол харьцангуй хараат бусаар бол нэг хэсэг ажиллаж байсан, нэр хүнд нь сайжирч байсан, олон улсын гаднын байгууллагын судалгаагаар ч тэгж гарч байсан. Сүүлийн 7, 8 жил бол уначихсан шүү дээ. Шүүхийн ерөнхий зөвлөл чинь бид нар 5, 5 хараат бусаар хүн тавилаа гэсэн сахилгын хороог нь тэгж тавилаа гэсэн. Үгүй ээ, тэр Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргыг ээлжлээд хийж болдоггүй юм уу. Тэр шүүгч нараас нь сонгогдсон хүмүүс. Заавал эндээс Улсын Их Хурлаас эрх мэдэлтэй хүмүүсээс тавьсан хүмүүс нь л даргыг нь хийж байх юм. Тэгээд л тэд нарын дохио зангаагаар ажиллаж байна. Энийг бол нийтээрээ ярьж байгаа шүү дээ ер нь бол. Одоо тэр хуулийг нь чангаруулах ёстой гэж Цогтбаатар гишүүнтэй би бол санал нэг байна. Тэгээд амь амьдралаа, хөрөнгө мөнгөөрөө, цаг

хугацаагаараа бүх юмаараа тоглуулчихсан хүмүүс. Тэгээд нөгөө шүүгч нар эрх баригч нарт юм уу хэн мөнгөтэй төгрөгтэй нь үйлчилхээд, нөгөө иргэд бол тэгээд хаягддаг эсвэл дайждаг, улс орноосоо явахаас өөр гарцгүй болдог. Тэгж хүмүүсийн амьдралыг шахаж байна шүү дээ. Улсын Дээд шүүх, бүх шатны шүүх шударга ажилладаггүй болохоор Үндсэн хуулийн цэц нь цэц шиг.../минут дуусав/

Б.Энхбаяр: Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хувьд Ганбат гишүүний асуултад хариулъя. Шүүхийн хууль бол 2 жилийн өмнө батлагдсан. Энэ дээр бол Ганбат гишүүн ер нь парламентад суудалтай бүхий л намууд шүүхийн шинэтгэлийг хийхийн төлөө санал нэгтэйгээр баталсан. Мэдээж нэг амьсгаагаар нэг дор сайжирчихна гэж мэдээж байхгүй. Тэр байтугай тухайн үед шүүхийн хуулийн дээр хэлэлцэж байхад одоо ажиллаж байгаа Монгол Улсын шүүгчдийг бүгдийг нь халаад хөөгөөд явуул. Тэгээд бүгдийг нь шинэ хүнээр сайхан сонгоё, тэгээд сайхан гоё болгоё гэдэг ийм санал яригдаж байсан. Би бол энийг дэмжээгүй, болохгүй. Шүүх эрх мэдэл хараат бус байх ёстой гэдэг нь хэрвээ тийм юм яасан бол одоо эрх барьж байгаа МАН жинхэнээсээ ёстой өөрсдийнхөө хүмүүсийг, гар хөлийнхөө хүмүүсийг шүүхээр тавилаа гэдэг ийм байдал руу орох байсан. Энэтэй холбоотой би нэг товч түүх хөндөхөд зуугаад жилийн өмнө 1930-аад оны Их хямралын үед бол Америкийн шүүхийн хараат бус байдал хамгийн дархлаатай гэдэг. Америкт Рузвельт Ерөнхийлөгч бол шүүх рүүгээ нэлээн асуудал үүсгэж байсан байна лээ. Маш том хэмжээний хямралтай, ажилгүйдэл ихтэй ийм үед том бүтээн байгуулалт, шинэчлэлүүдийг хийх, ажилгүйдлийг багасгах реформуудыг хийхийн тулд шүүх засаглалд өөрчлөлт оруулах асуудлыг хөндөж байсан юм билээ. Гэвч энийг дэмжээгүй. Яагаад? Яагаад гэхээр хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх гэсэн 3 эрх

мэдэл хэн нь ч хэнийхээ дээр даргалах ёсгүй. Эн тэнцүү бие биеэсээ хараат бус байх ёстой гэдэг тэр чек энд балансын зарчмыг хатуу баримталж, конгресс нь хэдий Рузвельт Ерөнхийлөгчийн олонх байсан боловч тэр бодлогыг нь дэмжээгүй, унагаж байсан юм байна лээ.

Нөгөө талаар яг Ганбат гишүүний хэлж байгаа шиг Перу улс бол ийм алдааг давтаж байсан юм байна лээ. Тухайн үеийнх нь эрх баригчид нь Ерөнхийлөгчид халдаж болохгүй Шүүх засаглалаа нэг хөндчихсөн чинь сүүлийн 60 жилийн турш олонх болсон засаг болгон, олонх болсон нам болгон шүүх эрх мэдлээ халж, солиод бүхэлдээ тэр Аргентины тэр өсөж байсан эдийн засагт бас сүйрч унахад нөлөөлсөн зүйл бол тэр тухайн үеийн олонх болсон улс төрийн нам, эрх баригчийн дур зорго хэт шүүх эрх мэдэлд нөлөөлснөөс бас үүдсэн гэдэг ийм дүгнэлтийг бас хийдэг юм байна лээ.

Дэлгэрсайхан гишүүн асуултаа асууя.

Б.Дэлгэрсайхан: Би товчхон нэг юм асууя. Ер нь Дээд шүүхийн захиргааны танхимын дарга байх Цогт шүүгч нь. Шүүгч билүү. Энийг Дээд шүүх цөөхөн хэрэг хянадаг болсон нэг талаасаа бас дэвшил зөв болж бас нэг шинжлэх ухаан тал руугаа явж байгаа боловч хүмүүсийн нэг хардаад байгаа юм бол үзэмжээрээ хэргүүдийг сонгож аваад байна уу даа гэж хардаад байгаа юм. Зарим юм дээр ч тэгж ер нь харагдаж байна лээ. Ялангуяа танай захиргааны шүүхийнхэн. Гадна, дотнынхон түрүүн Ганбат халти хэллээ бас үнэн шүү. Гадна, дотнынхтой нийлж хүний бизнес булааж авдаг жишиг бий болсон. Энийгээ та нар ер нь хэзээ засаж залруулах юм. Ийм жишээ яривал би чадна шүү. Баримттай бүр. Тийм учраас үүний нэгэнт зүгээр бол Цэцийн дүгнэлтийн асуудал ярьж байгаа учраас удаад нэг их тийм хүний нэр төрд халдсан юм яриад яах вэ. Энийгээ та нар

ялангуяа захиргааны шүүх дээр ах дүүгээрээ дамжиж хэрэг дамжуулж шийддэг юм байна. Танай шүүх чинь ер нь нэг жоохон цус ойртчихсон юм биш үү. Шат шатад үеэл ах дүүгээрээ байна шүү дээ. Бүгдээрээ Монгол жижигхэн мэдэж байгаа биз дээ. Тэгээд ийм нэг заваан юмаа хэзээ бий болгох юм. Ер нь шүүгчийг сонгохдоо ах дүү нь шүүхэд ажилладаг үгүй, хамаатан садан нь ажилладаг үгүй энэ тэрээ хэдүүлээ нэг хянаж, энд нь нэг хянадаг юм байхгүй бол ээж нь шүүгч байсан бол охин нь шүүгч болдог ч юм уу энэ чинь нэг тийм завхарсан тогтолцоо бий болж байна шүү дээ. Саяын тэр нэг би бас гайхаад байгаа юм. Илт яамны тийм залилангийн хэрэг тэгээд л хэрэгсэхгүй болгоод хаячихлаа шүү дээ. Би зүгээр нэрийг нь хэлээд яах вэ. Хийсэн хүмүүс нь хэргээ шүүх дээрээ хүлээгээд байдаг. Тэгтэл хэрэгсэхгүй л болгоод хаячхаж байгаа шүү дээ. Бодвол Цогт шүүгч энийг сонссон байлгүй. Тэгээд дээрээс нь бол газрын маргаан дээр бол ер нь дандаа л хууль бусаар авсан хүмүүсийн талд шийдвэр гарч байгаа шүү. Энд Монголд сохор хүн нэг ч байхгүй. Тэгээд л нэг Богд уулын газар гээд л баахан маргаад л явах юм. Уг нь илтэд хууль бусаар өгчихсөн л байх юм. Тэгээд шүүх нь дандаа л тэр авсан хүнийх нь зөв болоод л гарах юм. Тэгээд энэ мэтчилэн нэг ийм. Тэгээд ялангуяа Дээд шүүхэд би юу хэлэх гээд байгаа юм гэхээр таныг орж ирсэн дээр энэ хэргүүдийг ялангуяа захиргаа, иргэн дээр бол ер жоохон авъя гэсэнээ авч хянадаг нэг ийм захиалгаар татаж хянаад байна уу даа л гэж харагдаад байгаа шүү. Зүгээр эрүү бол ойлгомжтой л доо. Эрүү бол ямар ч хүн бас миний ял ихэдсэн барьсан би бас гэм буруугаа Дээд шүүх хүртэл явуулмаар байна гэдэг асуудал бол зөв л асуудал байх. Тэгэхээр энэндээ нэг товч хариулт байж болох уу. Хамаагүй гэж үзэх үү.

Б.Энхбаяр: 5 номерын микрофон.

Ц.Цогт: Ганбат гишүүн, Дэлгэрсайхан гишүүн нарын асуултын

өөрт гэдэг нь нөгөө Ерөнхий шүүгчээс Шүүхийн тухай хуулийн 25.7.5-тай холбоотой хэсэг дээр тайлбар хэлэх ийм төлөөлөгчөөр шүүгчдийн хуралдаанд ажлын хэсэг ахалж орсон гэдэг утгаар томилсон байгаа. Тэгэхээр хүрээнд хариулт хэлье гэж бодож байна. Түрүүн амжуулаад хэлчихье. Ганбат гишүүний хэлдгээр бол тэр шат шатны шүүх яагаад өөр өөр шийдвэр гаргаад байдаг юм бэ гэж.

Тэгэхээр анхан шатын шүүхийн чиг үүрэг бол нотлох баримтыг цуглуулаад, үйл баримт дүгнэлт хийгээд, тэгээд хууль хэрэглээг шийдэх ёстой. Давж заалдах шатын шүүх энийг нь бүрэн хянах ёстой. Өөрөөр хэлбэл үйл баримтаа зөв тогтоосон юм уу, дээрээс нь хуулиа зөв хэрэглэсэн юм уу. Тиймээс энэ дээр бол ялангуяа хууль хэрэглээ дээр хууль тайлбарлаж хэрэглэх арга зүйгээс хамаараад сонгож авсан арга зүйгээс хамаараад зөрж болдог. Зөрөхийг олон улсын үндэсний эрх зүй хүлээн зөвшөөрдөг. Гагцхүү хяналтын шатны шүүх нь энэ зөрүүг арилгах нэгдмэл хууль хэрэглээ байх чиг үүрэгтэйгээр эцэслэж шийддэг. Тийм учраас 3 шатны шүүхийн чиг үүрэг бол ийм байдлаар хуваарилагдсан байдаг.

Дэлгэрсайхан гишүүний асуултыг юу гэж ойлгосон гэхээр 3 шатны шүүхийн эцэс дээр байж байгаа хяналтын шатны шүүх хэргийг шийдвэрлэх тэр үндэслэлээ бол ямар шалгуураар авч шийдээд байна вэ гэдэг л ийм асуулт байна гэж ойлголоо. Тэгэхээр Шүүхийн тухай хуулийн 25.7.5 дээр 3 үндэслэл заачихсан байгаа. 3 үндэслэлд хамаарч байна уу, үгүй юу гэдгийг тухайн хэргийн анхан шатын шүүхийн шийдвэр, давж заалдах шатын шүүхийн шийдвэр тэр хэрэгт гарсан хяналтын гомдлыг судлаад танхимын нийт шүүгчид хуралдаад хэлэлцээд, тэгээд 4-ийн дүрэм буюу шүүхийн тухай хуульд заасан 4-өөс дээш шүүгчийн саналаар авна гэсэн шийдвэр гарсан тохиолдол авч байгаа. Зүгээр энд аль аль гишүүний асуултад хэлэхэд бол өнөөдөр Шүүхийн сахилгын

хороо, Шүүхийн ерөнхий зөвлөлийн хариуцах асуудлаар бол би тайлбар өгөх боломжгүй юм. Мөн нийт шүүгчдийн өмнөөс бас тайлбар хэлэх боломжгүй боловч өөрийнхөө өмнөөс тайлбар бол хэлж болох байх гэж бодож байна. Тэгэхээр Ганбат гишүүний танай намын засаг барьж байх үед ч тэр, нөгөө намын чинь засаг барьж байх ч үед би шүүгч хийж байсан. 20 жил шүүгч хийж байна. Нэг ч хэрэг танай намын эсвэл нөгөө намын чинь захиалгаар шийдэж байгаагүй, шийдэх сонирхол ч байхгүй. Тийм учраас шүүгч нар бол бүгдээрээ гэдэг юм уу, шүүгч нар тийм байдлаар шийддэг гэж үзэж бас олон нийтэд ойлголт өгч болохгүй байх гэж бодож байна.

Б.Энхбаяр: Гишүүд асуулт асууж дууслаа. Цэцийн дүгнэлттэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Ганбат гишүүнээр тасаллаа. Энх-Амгалан гишүүн үг хэлье.

Б.Энх-Амгалан: Нэг зүйлийг бас анхаарах хэрэгтэй. Цэцийн дүгнэлтийг бол хүлээж авах нь зүйтэй гэж бодож байгаа юм. Хүний эрхтэй холбоотой асуудлаар ингээд нэлээн нарийн мэдрэмжтэй хандахгүй бол хэлмэгдүүлэлт гээч юм шинэ цагийнхаа хувилбарт шилжээд явах магадлал өндөр байна аа. Хуулийн байгууллага мөрдөж байгаа хэргээ гаргаж ирж, олон нийт хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацдаг. Тогтоолтойгоо танилцаж амжаагүй байхад ийм юм болж гэнэ гээд урьдчилаад мэдэгддэг. Тэгээд сүүлд нь тэр хэргийнх нь материалуудыг хүлээж аваад сайтын мэдээллийг нотлох баримт болгож авдаг. Тэгээд үүнийхээ дараа шүүх яаж шийдэхийг нь харна аа гээд сууж байдаг. Ийм байдлаар хэргийг мөрдөн шалгах ажиллагаа явагдаж болох юм уу. Нэг ёсондоо энэ чинь шүүхэд хөндлөнгөөс нөлөөлж байгаа хэрэг мөн үү, биш үү гэж ингээж хардахад хүргэж байгаа юм. Цаашидаа ийм байдлаар яваад байх юм бол энэ чинь өөрөө яг шинэ цагийн хэлмэгдүүлэлтийн маш том

суурийг тавих ийм айхтар нөхцөлд байгаа учраас хүний эрхтэй холбоотой асуудлаар бол их мэдрэмжтэй хандах ийм шаардлага хэрэгцээнүүд байна аа.

Нөгөө талаар ингээд нэг талаар хүнийг гэм буруутайг нь нотлох нотлох баримтыг цуглуулах ёстой. Нөгөө талаар гэм бурууг нь нотлох бас тийм цагаатгах баримтыг давхар цуглуулах ёстой. Нэг талыг нь барьж баахан мэдээлэл авчхаад нөгөө мэдээллээрээ заавал явуулаад тийм санаа зорилготой юм шигээр ингэж ажиллах ийм нөхцөл байдлууд ер нь нэлээн газар авч байна гэж олон хүмүүс яриад байгаа юм. Энэ нөхцөл байдал дээр бас нэлээн шүүх хараат бус гэдгээ ингэж хийхгүй бол тэгээд сүүлд нь явж байгаад шүүх хуулиа бариад шийдвэр гаргахаар авлигач шүүгч буруу шийдвэр гаргасан гэдэг ийм юм руу шүүхийг түлхэж болохгүй юм аа. Нэг ёсондоо нийгмийн уур амьсгал, сошиалын уур амьсгалыг дагаж хууль шийддэг ийм байж ерөөсөө болохгүй. Ийм нөхцөл байдал байгаа учраас хүний эрхийн асуудал дээр бол маш мэдрэмжтэй хандах ийм цаг хугацаа болжээ гэдгийг бас би хэлэх гэж байгаа юм. Баярлалаа.

Б.Энхбаяр: Раднаасэд гишүүн үгээ хэлье.

Ш.Раднаасэд: Би цэцийн шийдвэрийг ойлгохгүй юм. Зөрчөөгүй байна гээд, тэгээд түдгэлзүүлсүгэй гээд. Би ажлын хэсэгт байхад ялангуяа хуулийг Улсын дээд шүүхийн тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн бол Дээд шүүх үзнэ гээд энийг эсэргүүцэж байсан юм аа. Дээд шүүхийн тайлбар төгс юм уу, хууль нь төгс юм уу. Аль нь анхдагч юм гэж. Хуулиа барь. Хууль, Дээд шүүхийн тайлбар 2 зөрвөл шүүгч алийг нь барих юм гээд. Тэгээд энийгээ одоо бол хүлээж аваад засах юм байна гэж ойлголоо. Тийм үү.

2 дугаарт шүүгч дотоод итгэл үнэмшилээрээ шүүнэ гэдэг тэр 25.7 дээр нөгөө анхан болон давж заалдах шатын

шүүх. Энэ бол анхан шат дээр өөр гараад, давах дээр өөр гарчихаар л Дээд шүүх дээр үүсэх үү, үүсэхгүй юү гэдэг асуудал яриад байгаа шүү дээ. Маргаан тийм үү. Энийгээ яг яаж тодорхойлж ойлгодог юм бас ойлгомжгүй байсан. Энэ бас Цэц дээр гарчихсан юм байна. Тэгээд аваад янзлахдаа чухам ямар хүрээнд янзлах вэ гээд дахиад хуулийн төсөл орж ирэх юм байна. Тийм юм байхгүй байна ерөөсөө. Улсын Дээд шүүхийн бичиг гэж энд байхгүй байна. Энэ юмнуудаа нэг цэгцлэхгүй бол гишүүдийн яриад байгаа ялангуяа шинэ Шүүхийн хуультай холбоотой гомдол маргаан их гараад байх шиг байгаа шүү. Нөхцөл байдал юмыг харж байхад. Чухам энэ алдаануудаа бид нар яах вэ засаад л бага багаар засаад л явах үүний цаана дахиад л хүний эрхийн асуудал дахиад л хөндөгдөнө. Үзэмжээрээ асуудал ханддаг гэдэг бас л яригдаж л байсан юм. Анхан шат нь илт зөв шийдсэн байхад давах нь буруу шийдээд, тэгээд л Дээд шүүх дээр дахиж шийдээд ингэчихлээ гээд л. Эргэн тойронд тийм жиг жууг янз янзын ярианууд их л сонсогдох юм. Тэгээд эргээд яг энэ хайрцаараа авах юмаа аваад, авахгүй юмаа авахгүй гээд ингээд шууд хийгээд байдаг. Би бол хяналтын журам дээр бол бүх хэрэг биш юм гэхэд энэ хоёрыгоо өшөө жоохон дэлгэрүүлсэн байдлаар яах ёстой юм. Тэр юмыг нь давхар л явуулж байх ёстой л гэж саналтай байгаад байгаа юм.

2 дугаарт нэг санал. Цэцийн ийм дүгнэлт ер нь урьд өмнө нь гарч байсан юм уу. Зөрчөөгүй байна, тэгэхдээ түдгэлзүүлсүгэй гэж. Үгүй ээ, энэ зөрчөөгүй байна аа л гэж байна. Тэгээд 12 сарын 15-ны өдрөөс эхлээд түдгэлзүүлсүгэй гээд. Одоо бол хэрэглэхгүй байгаа юм байна шүү дээ заалтыг. Энийгээ нэг мөр болгохгүй бол ингээд зөрчөөгүй байна. Яах вэ Үндсэн хууль болон бусад хууль 2022 онд сая 8 сард бид нар нэг өөрчлөлт хийхдээ хийсэн. Тэгэхдээ энэ дээр нэг их тийм шийдвэрийг нь ийм байдлаар бичих ёстой тэгж гаргаагүй дээ би бодоход. Тэгээд

нэг ийм ойлгомжгүй юмаа Цэцтэй нэг мөр болгохгүй бол зөрчөөгүй байна тэгээд түдгэлзүүлсүгэй гээд ингээд байх. Заавал энэ чинь хүчээр тулгаж хууль тогтоогчийг хуульд засуулах гээд байна шүү дээ. Зөрчөөгүй байна. Тэгэхдээ та нар энийгээ зас гээд. Тэгээд энэ чинь хууль тогтоох эрх нь бид нарт байна уу, эсвэл Цэцэд нь байна уу. Ингээд түдгэлзүүлээд хаячихаар энэ хууль чинь хэрэглэхгүй болчихож байгаа байхгүй юу. 27-гийн хэд гээд хяналтын журмаар Дээд шүүх авч хэлэлцэж байгаа бүх хэргүүд энэ хуулийн.../минут дуусав/

Б.Энхбаяр: Ганбат гишүүн үгээ хэлье.

Д.Ганбат: Би тэр 2 гишүүний ярьсныг үргэлжлүүлээд ярья аа. Тэр нь бараг ер нь тэгээд тодорхой л байна шүү дээ. Хууль хэн нь тогтоогоод байна вэ гэдэг нь. Тэгээд ийм л байна л даа. Тэр анхан шатын шүүх маань өөрөө л хараат бус, бие даасан ийм шийдвэрээ л гаргах ёстой. Тэр процессын алдаа тэр хууль нэгдмэл хэрэглээний тийм юмаа л хянадаг барьдаг тийм л юм байдаг байх. Тэгээд зарим нэг нь болохоор давж заалдаад, хянуулаад ингээд явчихдаг. Зарим нэг нь тэрийгээ мэдэхгүй явж байгаад тэгээд хохироод үлдвэл тэгээд тэр чигтээ хохироод үлдэх юм уу. Нэг ийм л юм байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр хуульдаа байна уу, юундаа байгаа юм. Тэр Дээд шүүхийнхээ тайлбартай байдаг юм уу. Дээд шүүх нь татаж аваад хэргийг шийдэх сонирхолтой байдаг юм уу? Энэ юм дээрээ нэг цэг тавиад, анхан шатын шүүх чинь л өөрөө хараат бусаар бие даагаад шийддэг ийм л шүүх байх ёстой шүү дээ. Болохгүй юмаа тэр лүүгээ буцаагаад л явуулах ёстой шүү дээ. Тэр процессын алдаа гарсан байна. Хууль нэгдмэл хэрэглээгүй байна. Тэгээд тэр анхан шатынхаа шүүх чинь шийдвэр гаргасан шүүгчээ тэр дээр нь арга хэмжээ авдаг л байх ёстой байхгүй юу. Би тэгж л ойлгоод байна шүү дээ. Тэгэхгүй бол Дээд шүүх нь хараат бусаар

бие дааж шийддэг, бусад шүүхүүд нь шийддэггүй маягтай. Тэгээд шийдүүлсэн хүмүүс нь хохироод үлддэг маягтай ийм ойлголт өгөх гээд байна аа.

Тэгээд манай Дээд шүүх их гоё байгаа юм ярьчихав уу та. Үгүй ээ би тэгж ойлгохгүй л байгаа шүү дээ. Юу билээ тэр миний хэлсэн үг биш шүү. Тэр компанийн захирлын арын өрөөнд хундага аягалаад зогсож байсан гээд л энэ гүйцэтгэх засаглалын тэргүүн чинь хэлсэн шүү дээ. Бүгдээрээ л Монгол даяараа сонсож байсан. Тэгээд тэрнийхээ дараа ямар арга хэмжээ авсан юм. Ямар тайлбар тавьсан юм тэр чинь байхгүй л байгаа шүү дээ. Тэгээд ийм нэр хүндтэй шүүхэд хэн итгэх юм. Нөгөө хараат бус байна гэж яаж ойлгох юм. Тэгээд одоо нэг Улсын Их Хурлын гишүүн байсан эмэгтэй тэр тавьсан эзэндээ л зүтгэдэг гээд л нэр заагаад л шүүмжилж байна лээ шүү дээ. Тэр нь тийм, тэрний үед тавигдсан, тэрэнд үйлчилдэг гээд л. Үгүй ээ, одоо юм сайхан болж дээ. Нөгөө хэлсэн, ярьсан бүх юм нь бичлэг болоод үлддэг. Сошиалд байдаг. Хэн хүссэн хүн нь товч дараад л ороод харчхаж болдог болчихсон шүү дээ. Нэг ингээд шуугиад өнгөрөх биш ээ. Тэгээд яг шүүх гэдэг үүргээ өөрийнхөө үүрэг ролийг хэрэгжүүлмээр байна аа. Тэр намыг нь тараадаг, тэр арга хэмжээг нь авдаг, Шүүхийн ерөнхий зөвлөлөө олигтойхон ажиллуулдаг, шүүхийнхээ сахилгын хороогоор шийддэг ийм байх л зөв шүү дээ. Бүх юмнууд нь байж байдаг. Нөгөө институцүүд нь, ажиллах ёстой байгууллагууд нь яагаад ингээд ажилладаггүй юм. Бодвол одоо тэр хуулийн зүйл, заалт хариуцлага тооцох тэр механизмыг нь дутагдалтай болохоор л ингэж яваад байна гэж ойлгож байна.

Шүүхийн шинэтгэлийн талаар Улсын дээд шүүх дээр, Шүүхийн ерөнхий зөвлөл дээр, Шүүхийн сахилгын хороо дээр, Хууль зүйн яаман дээр яригдаж байгаа байх аа. Энэ дээр та нар бас ажиллаарай. Энэ маягаараа удаан яваад

байвал энэ улс орон чинь сүйд болж байна шүү. Гаднын хөрөнгө оруулалт сүүлийн 8 жил унаж байна шүү дээ. Юунаас болж байна хараат бус шүүх алга. Ер нь гаднын хөрөнгө оруулалтуудыг дээрэмдсэн юм зөндөө байдаг юм байна лээ шүү дээ. Хууль зүйн сайд нь бол нэр заагаад л ярьж байсан. Ийм л зүйлүүд байгаа шүү. Энэ юмыг хэлэх, ярих зөв байх гэж бодож байна. Тэртээ тэргүй хэлээд яриасай гэж ард түмэн хүлээж л байгаа. Би бол анхан шатын шүүгч нарыг сайн ажилладаг гэж бодож байгаа. Сайн ажиллаж байсан шүүгч нар байсан. Одоо шинээр тавьж байгаа нь ямар байгаа юм гэхээс биш. Нэг хэсэг бол их нэр хүндтэй байсан шүү дээ. Гаднын байгууллагын юугаар бол овоо аятайхан болж байна гээд. Улсын дээд шүүх мэдэхгүй ээ, мэдэхгүй. Тэр хариултаа та нар гарч ирж өг.../минут дуусав/

Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалт явуулна. 9 санал хураалт явагдана.

Шүүхийн хуулийн ажлын хэсгийн ахлагч мөн шүүхийн хуулийн Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон гишүүний хувьд бол Цэцийн дүгнэлтийг хүлээж авъя гэсэн ийм байр суурьтай байгаа. Тэгээд дүгнэлтийг хүлээж авсантай холбоотойгоор бас холбогдох хуулийг боловсронгуй болгох чиглэлд нэмэлт, өөрчлөлтийг даруйхан оруулж шүүн таслах үйл ажиллагаанд ямарваа нэгэн маргаан, тасалдал, эргэлзээ үүсгэхгүйгээр явах нь ач холбогдолтой байх гэж ингэж үзэж байгаа. Тийм учраас хаврын чуулгандаа багтаагаад нэмэлт, өөрчлөлтийг нь оруулъя. Энэтэй холбоотой харин Улсын дээд шүүхийн судалгааны хүрээлэнгээс маш дэлгэрэнгүй яг энэ 3 заалттай холбоотой тухайлсан дэлгэрэнгүй судалгаа хийгдсэн байгааг Байнгын хорооны бүх гишүүд тараасан байгаа шүү. Та бүхэн маань бас сайн танилцаарай. Тодорхой кэйстэй ч холбогдуулж, мөн бусад улс орны

туришлага харьцуулсан эрх зүйн чиглэлээр сайн судалгаа хийгдсэн байгааг танилцуулсан. Мөн тодорхой саналын томъёоллыг Улсын Дээд Шүүх ирүүлсэн байгаа. Энийг бас та бүхэн маань үзээрэй. Тэгээд Улсын Их Хурал хэрвээ энэ 7 хоногт хүлээж авах нь зүйтэй гэдэг шийдвэр гарвал ирэх 7 хоногийн Байнгын хорооны хуралдаанаар хүлээж авсантай холбоотой холбогдох санал, дүгнэлтийг Байнгын хорооны хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байгаа гэдгийг хэлье ээ.

Санал хураалт.

Нэг.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.5.а дэд заалтад “анхан болон давж заалдах шатны шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах;” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад Монгол Улсын иргэн “... шударга шүүхээр шүүлгэх, ... эрхтэй. ...” гэж заасанд нийцээгүй байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт 61,5 хувийн саналаар саналыг хүлээж авлаа.

2 дахь санал хураалт.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7.5.б дэд заалтад “хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн;” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад Монгол Улсын иргэн “... шударга шүүхээр шүүлгэх, ... эрхтэй. ...” гэж заасанд нийцээгүй байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт 72.7 хувийн саналаар саналыг хүлээж авлаа.

3 дахь санал хураалт.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.1 дэх заалтад “анхан болон давж заалдах шатны шүүх хуулийг

зөрүүтэй хэрэглэсэн;” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад Монгол Улсын иргэн “... шударга шүүхээр шүүлгэх, ... эрхтэй. ...” гэж заасанд нийцээгүй байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт 72.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4 дэх санал хураалт.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.3 дахь заалтад “шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад Монгол Улсын иргэн “... шударга шүүхээр шүүлгэх, ... эрхтэй. ...” гэж заасанд нийцээгүй байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт 54,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5 дахь санал хураалт.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1 дэх заалтад “анхан болон давж заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийг зөрүүтэй хэрэглэсэн;” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад Монгол Улсын иргэн “... шударга шүүхээр шүүлгэх, ... эрхтэй. ...” гэж заасанд нийцээгүй байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт 63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6 дахь санал хураалт.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.3 дахь заалтад “шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн.” гэж заасан нь Монгол Улсын

Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад Монгол Улсын иргэн “... шударга шүүхээр шүүлгэх, ... эрхтэй. ...” гэж заасанд нийцээгүй байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт 63,6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7 дахь санал хураалт.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 40.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “... зөрүүтэй хэрэглэсэн эсэх, ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад Монгол Улсын иргэн “... шударга шүүхээр шүүлгэх, ... эрхтэй. ...” гэж заасанд нийцээгүй байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт 72,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8 дахь санал хураалт.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 172 дугаар зүйлийн 172.2.1 дэх заалтад “анхан болон давж заалдах шатны шүүх хуулийг зөрүүтэй хэрэглэсэн;” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад Монгол Улсын иргэн “... шударга шүүхээр шүүлгэх, ... эрхтэй. ...” гэж заасанд нийцээгүй байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт 72.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9 дэх санал хураалт.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 172 дугаар зүйлийн 172.2.3 дахь заалтад “шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад Монгол Улсын иргэн “... шударга шүүхээр шүүлгэх, ... эрхтэй. ...” гэж заасанд нийцээгүй байна гэснийг хүлээн

зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт 72,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 2 дугаар дүгнэлтийг хэлэлцэж дууслаа.

Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 02 дугаар дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд би танилцуулъя.

17.04 цаг.

Дараагийн асуудалд оръё. Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төсөл

/Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяагаас 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг нэгтгэн хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий/ Ажлын хэсэг байгуулах тухай асуудлыг хэлэлцэж эхэлье.

Холбогдох тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа.

Тогтоолын төслийг уншиж сонсоё. Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол. Ажлын хэсэг байгуулах тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5 дахь

хэсгийг үндэслэн Хууль зүйн байнгын хорооноос тогтоох нь.

Нэг.Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяагаас 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг нэгтгэн Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Ж. Сүхбаатар Улсын Их Хурлын гишүүн.

Гишүүд Пүрэвдорж Улсын Их Хурлын гишүүн, Мөнхбаатар Улсын Их Хурлын гишүүн.

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Хатантуул Хууль эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх.

Хоёр.Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх ажлын дэд хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Болортуяа Хууль эрх зүйн газрын зөвлөхүүдийн албаны зөвлөх. Сайнзориг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга. Цолмон Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Гантуяа Монгол банкны Удирдлага төлөвлөлтийн газрын Мөнгө угаах терроризмыг

санхүүжүүлэхтэй тэмцэх асуудал хариуцсан ахлах референт, Ш.Цолмон Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч, М.Цолмон Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын шинжээч, Б.Баярсайхан Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн албаны дарга, П.Хулан Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан референт.

Гурав.Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр холбогдох байгууллагаас мэргэжлийн хүмүүсийг оролцуулж ажиллуулахыг ажлын хэсгийн ахлагч Ж. Сүхбаатарт зөвшөөрсүгэй гэсэн тогтоол байна аа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Тогтоолын төсөлтэй холбоотойгоор гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна. Тогтоолын төсөлтэй холбогдуулан гишүүд үг хэлж дууслаа.

Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 72,7 хувийн саналаар тогтоолын төсөл батлагдлаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье ээ гишүүддээ.

17.07 цаг.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ